



Оюу Толгой ХХК

Эрүүл мэнд, Аюулгүй ажиллагаа болон Байгаль
орчны удирдлагын тогтолцооны журам

10-р хэсэг. Зам барих, засвар үйлчилгээ хийх журам
(СЗ Тээврийн хэрэгсэл ба жолоодлогын аюулгүй ажиллагааны
стандарт)

| Зам барих болон замд засвар үйлчилгээ хийх журам | | |
|---|---|------------------|
| Хүчин төгөлдөр болох огноо: 2012.04.16 | Баримт бичгийн дугаар: ОТ-10-СЗ-PRC-0001-М | Хувилбар: 1.1 |

1 ЗОРИЛГО

Энэхүү журмын зорилго нь алслагдсан Говийн нутаг дахь Оюу Толгой дахь ажиллагаанд замын загвар, барилга, засвар үйлчилгээний ажлын туршлагаудын талаар хангалттай мээдээллээр хангаж замын гадаргууг оновчтой болгоход оршино.

Замын загвар, барилга, засвар үйлчилгээний ажлыг Оюу Толгой ХХК болон Рио Тинто Групп дотор өндөр эрсдэлтэйд тодорхойлсон байна.

2 ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү журам нь Оюу Толгой ХХК-ий бүх ажилчид, гүйцэтгэгчид хамаарна. Үүнд Оюу Толгой ХХК-ий эсвэл түүний гэрээт гүйцэтгэгчдийн төслийн талбай дахь эсвэл ажлын зорилгоор төслийн талбайгаас өөр газарт эзэмшиж байгаа эсвэл ашиглаж байгаа бүх замд хамаарна.

3 ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

| Үүрэг | Хариуцлага |
|--|---|
| Ажилчид, Гүйцэтгэгчид болон Зочид | <ul style="list-style-type: none"> Тээврийн хэрэгслийг заасан хурдны хязгаарын дотор, болгоомжтой, нөхцөл байдалд анхааралтайгаар жолоодох ёстой. Архи эсвэл бусад мансууруулах бодисын нөлөөнд дор байгаа хүмүүс Оюу Толгойн Архи болон бусад мансууруулах бодисын Бодлогын дагуу тээврийг хэрэгслийг жолоодож болохгүй. Тээврийн хэрэгслийн ажиллуулахын өмнөх болон аюулгүй ажиллагааны үзлэгийг хийнэ. Тээврийн хэрэгслийн аливаа эвдрэл доголдлыг аль болохоор хурдан мэдэгдэнэ; Тээврийн хэрэгслийн аюулгүй ажиллагаанд нөлөөлөх аливаа осол, доголдол (жишээлбэл тоормосогд эсвэл жолоонд) гарсан бол, нэн даруй мэдэгдэж “АЖИЛЛАГААГҮЙ” гэсэн шошго наана. Тээврийн хэрэгслийг цэвэр, эмх цэгцтэй байлгана. |
| Супервайзор | <ul style="list-style-type: none"> Түрээсэлж, эзэмшиж байгаа эсвэл лизингаар авсан тээврийн хэрэгслийг үйлдвэрлэгчийн зөвлөмжийн дагуу болон лизингийн эсвэл түрээсийн байгууллагын зааварчилгааны дагуу засвар үйлчилгээ хийнэ. |
| Ахлах мэргэжилтэн | <ul style="list-style-type: none"> Үргэлжилсэн үйл ажиллагаанд ашиглаж байгаа тоног төхөөрөмжийг ээлж болгонд тогтоосон аюулгүй ажиллагааны шалгалтын стандартын дагуу шалгаж байна. Ховор ашиглагддаг тоног төхөөрөмжийг ашиглахаас өмнө шалгана. |
| Дараагийн шатны Удирдлага (LOR) / Менежер | <ul style="list-style-type: none"> Ажлын зорилгоор ашиглагдаж байгаа бүх тээврийн хэрэгсэлд <i>СЗ Тээврийн хэрэгсэл ба Жолоодлого Аюулгүй Ажиллагааны Стандартын</i> шаардлагын дагуу эрсдлийн дүн шинжилгээ хийх ёстой. Эрсдлийн шинжилгээг тээврийн хэрэгсэлд хадгална. |

| Зам барих болон замд засвар үйлчилгээ хийх журам | | |
|---|---|------------------|
| Хүчин төгөлдөр болох огноо: 2012.04.16 | Баримт бичгийн дугаар: ОТ-10-СЗ-PRC-0001-М | Хувилбар: 1.1 |

| | |
|---------------------------------|--|
| | <ul style="list-style-type: none">Хүнд тээврийн хэрэгсэл болон үйл ажиллагааны талбайд ажлын зорилгоор хөнгөн тээврийн хэрэгсэл жолоодох шаардлагатай хүн бүр жил болгон Жолоч нарын Жил бүрийн Шалгах хуудас бөглөж аюулгүй жолоодлогын арга барилыг сайжруулна.Чирэхэхээр зориулагдаагүй тээврийн хэрэгслийг өөр тээврийн хэрэгсэл чирэхэд ашиглаж болохгүй.Олон нийтийн замд болсон тээврийн хэрэгслийн осол зөрчил болон осол аваарыг хууль тогтоомжийн шаардлагын дагуу орон нутгийн засаг захиргааны байгууллагад мэдэгдэх ёстой. Компаний тээврийн хэрэгслийн оролцоотой осол болон замын дүрмийн зөрчлийг зохих газарт мэдэгдэж, шинжилгээ хийх ёстой. |
| Хэлтсийн Ерөнхий Менежер | <ul style="list-style-type: none">Тээврийн хэрэгсэл болон жолоодлогын аюулгүй байдалд нөлөөлөх нөхцөл байдлын ба зан төлөвийн хүчин зүйлүүдийг тодорхой тогтоохын тулд төслийн талбай бүрт СЗ Тээврийн хэрэгсэл ба Жолоодлого Аюулгүй Ажиллагааны Стандартын <i>ОТ-10-СЗ-STD-0003-EJ</i> шаардлагын дагуу эрсдлийн цогц дүн шинжилгээ хийгдсэн байхыг хангана. Төслийн талбай бүрт дүгнэлтээр илэрсэн асуудлыг шийдвэрлэх ажлын төлөвлөгөө боловсруулж гүйцэтгэлийг хянана.Төслийн талбайн СЗ Хороо хурдны хязгаар, замын тэмдэглээ болон замын дүрмийн биелэлтийг тогтмол хянаж урамшуулахыг хангана. |

4 ЖУРАМ

4.1 Загварын үе шат

4.1.1 Уурхайн цаг уурын ангилал

Том оврын ачааны машины замыг барихад нөлөө үзүүлэх цаг уурын нөхцөл байдлаар уурхайг ангилахад тус дөхөмтэй байдаг, тухайлбал: Хуурай, Чийглэг, Хүйтэн.

Жилийн улиралаас хамааран нэг уурхайд эдгээр цаг уурын нөхцөл байдлын хоёр (эсвэл гурав) нь таарч болно. Цаг уурын ангилал бүр өөрийн онцлогтой байдаг, хамгийн чухалыг нь доор дурьдах болно.

4.1.1.1 Хуурай уурхай

Хуурай уурхайд гардаг томоохон аюулгүй ажиллагааны асуудал нь тоос юм. Амьсгалаар тоос орох нь ажлын байрны эрүүл мэндийн ноцтой асуудал үүсэхэд хүргэж болзошгүй. Амьсгалаар орсон болон амьсгалаар ороогүй тоос нь үзэгдэх орчныг багасгаж чадах бөгөөд энэ нь тээврийн хэрэгсэл мөргөлдөх эрсдлийг үүсгэх аюултай. Холбох материалыг тоос болгож алдах нь (эсвэл холбох материал хүрэлцэхгүй байх нь) замын гадаргууг салахад хүргэж болох бөгөөд энэ нь сийрэг материал бий болгон замын үрэлтийн асуудал үүсгэнэ. Атираа (замын эвдрэл) бол мөн хуурай уурхайтай холбогдох нэг бэрхшээл юм.

4.1.1.2 Чийглэг уурхай

| Зам барих болон замд засвар үйлчилгээ хийх журам | | |
|---|---|------------------|
| Хүчин төгөлдөр болох огноо: 2012.04.16 | Баримт бичгийн дугаар: ОТ-10-СЗ-PRC-0001-М | Хувилбар: 1.1 |

Шавар болон тогтворгүй хучилт нь чийглэг уурхайд гардаг том бэрхшээлүүд. Шавар нь үрэлтийг багасгаж, өнхрөлтийн эсэргүйцэлийн хүчийг нэмэгдүүлж, элэгдлийн гадаргууг чийгтэй болгон зөөлрүүлнэ. Энэ нь ус сувгийг бөглөж, замын хучилтыг дүүргэж эвдрэхэд хүргэнэ. Замын засвар, үйлчилгээний ажил хийх үед замын гадаргуунаас салсан хучилтын материалыг зам шавартай үед дахин ашиглаж болохгүй тул хучилтыг шинэчлэх шаардлага нь чийглэг, шаварлаг нөхцөлд ихээхэн нэмэгдэнэ.

Чийглэг, шаварлаг нөхцөлд тээврийн хэрэгсэл явах үед чийгтэй хучилтаас дугуй нь дээшээ хөөрөхөд ихээхэн соролтын хүч үүсгэж болно. Эдгээр соролтын хүчнүүд тээврийн хэрэгслийн хурд нэмэгдэхээр өсдөг бөгөөд хучилтын хэсгийг салгаж, хучилтыг сайн нягтаршуулахгүй бол маш хурдан нүх гаргана.

Ус зайлуулах нь чийглэг уурхайд маш чухал асуудал байдаг. Усыг хүрэлцээтэй хэмжээгээр зайлуулж чадахгүй бол хучилтанд ус нэвтрэн орж, хучилтын эвдрэлд хүргэнэ. Дэвсгэр үе нь сул эсвэл хучилтын доод үе нь харьцангуй сул сийрэг материалаар барисан бол энэ нь яланагуяа маш чухал болдог.

4.1.1.3 Хүйтэн уурхай

Мөс бол үрэлт алдагдахад хүргэдэг бөгөөд хайлах үед хучилтын эвдрэл үүсгэдэг. Хөлдөж хайлахаас үүсэх хөрсний өргөлт нь: хучилтыг сулруулж эвдүүлдэг, мөс хайлах нь мөн чийглэг уурхайд муугаар нөлөөлнө.

Шинэ цас мөн үрэлтийг алдагдуулж ус зайлуулах суваг болон замыг хаадаг.

4.1.2 Хучилтын загвар

Хучилт гэдэг нь гүйлтийн гадаргуу болдог дэвсгэр үеэс дээш замын хэсэг юм.

Хучилтын загварын зорилго нь хамгийн зардал багатай хучилтын зузаан болон найрлагыг сонгож төлөвлөгдөж байгаа замын хөдөлгөөнд үйлчилгээний хангалттай түвшинг хангахад оршино. Үүнд, хамгийн бага зардалтай гэдэгт нь нэг тонн тээвэрлэхэд гарах нийт зардлыг ойлгох бөгөөд том оврын машины замын барилга, засвар үйлчилгээ, тээврийн хэрэгслийн үзүүлэлт зэргийг тооцсон болно.

Рио Тинтогийн Том оврын машины замын загвар, барилга болон засвар үйлчилгээний Зааварчилгаа (Лавлагаа А) Хэсэг 2.2-с замын хучилтын загварын талаар нарийвчилсан зөвлөгөө, зааварчилгааг авна уу.

4.1.3 Ус зайлуулах суваг

Замын ус зайлуулах суваг, байгалийн урсгал устай адил, ус болон тунадасыг зөөж гаргадаг. Үйл ажиллагааны зарим үе шатанд, уурхайн талбай их хэмжээний тунадас гаргадаг бөгөөд эдгээрийг зайлуулах нь бохир уснаас хэцүү төвөгтэй байдаг. Суваг болон усны хоолойны загвар нь тунадасыг тээвэрлэх болон доош буулгахад их нөлөөлдөг.

Лавлагаа А Хэсэг 2.3-с ус зайлуулах сувгийн талаархи нарийвчилсан зөвлөмж, зааварчилгааг авна уу.

4.1.4 Замын хэлбэр

Зам нь санхүүгийн хязгаарлалтын дотор инженерийн сайн туршлагад нийцсэн байх ёстой бөгөөд дараах үзүүлэлттэй байна:

- Замын градиент нь барилгын зардал (хаягдал зайлуулах нь орсон) болон тээврийн хэрэгслийн амьдралын мөчлөгийн үзүүлэлтэд тохируулан хамгийн оновчтой байна.
- Үзэгдэх орчны хангалттай аюулгүй зай байна.
- Зөрж өнгөрөхөд хангалттай өргөнтэй байна.

| Зам барих болон замд засвар үйлчилгээ хийх журам | | |
|---|---|------------------|
| Хүчин төгөлдөр болох огноо: 2012.04.16 | Баримт бичгийн дугаар: ОТ-10-СЗ-PRC-0001-М | Хувилбар: 1.1 |

- Өргөгдсөн хажуу муруйтай байна.
- Ус зайлуулахад үр нөлөөтэй хөндлөн налуутай байна.

Лавлагаа А Хэсэг 2.4-с замын хэлбэрийн талаархи нарийвчилсан зөвлөмж, зааварчилгааг авна уу.

4.1.5 Уулзвар

Замын уулзвар бол замын системийн хамгийн аюул эрсдэлтэй хэсэг юм. Муу загвартай уулзвар нь замын хөдөлгөөний чиглэлийг зөрчилдүүлж хөдөлгөөнд саад учруулдаг. Үүнээс болж энэ талбайд тээврийн хэрэгсэл мөргөлдөх боломж нэмэгдэнэ.

4.1.5.1 Аюулгүй уулзварын зарчимууд

Уулзварын загвар зохиоход аюулгүй байдал нь нэн тэргүүний асуудал мөн. Аюулгүй уулзварын загвар нь дараах зарчим дээр тулгуурласан байна:


- Зөрчилдөх цэгүүдийн тоог багасгах;
- Зөрчилдөх талбайг багасгах;
- Зөрчилдөх цэгүүдийг хоорондоо салгах;
- Их хөдөлгөөнд нь давуу тал олгох;
- Хурдыг хянах;
- Явах замыг тодорхойлох; мөн
- Тодорхой, зөв байрлуулсан тэмдэг, тэмдэглээ.

4.1.5.2 Уулзварын төрөл ба хэлбэр

“Т” үсгийн хэлбэртэй уулзвар хамгийн хялбар бөгөөд аюулгүй уулзвар бөгөөд гол замын хөдөлгөөн нь давуу эрхтэй байна. Уулзварын өнцөг нь 90 градус байна, хамгийн бага нь 70 градус, энэ нь тухайн замын хөдөлгөөний урсгалын хангалттай үзэгдэх орчноос хамаарна. Уулзварын өнцөг 70 градусаас бага байвал, уулзварын хэлбэрийг өөрчилж хамгийн бага өнцөгийг бий болгох (Зураг 1), эсвэл үзэгдэх орчин багатай тээврийн хэрэгсэл гол зам руу (тэд нарт зам тавих) орохоор тохируулах ёстой.

| Зам барих болон замд засвар үйлчилгээ хийх журам | | |
|--|---|------------------|
| Хүчин төгөлдөр болох огноо: 2012.04.16 | Баримт бичгийн дугаар: ОТ-10-СЗ-PRC-0001-М | Хувилбар: 1.1 |

Зураг 1 Уулзварын Жишээ



Огтлолцол уулзвар нь өндөр хурдтай уулзвар өнгөрөхөөс сэргийлэх арга хэмжээ авахгүй бол ихэнх тохиолдолд тохиромжгүй байдаг. Гол замыг заах нь тухайн газрыг сайн мэдэхгүй жолооч нар байвал үр дүнд хүрэхгүй байж болно. Огтлолцол замын оронд шат дараалсан Т үсгийн хэлбэртэй уулзвар байж болно, үүнд нэг, эсвэл хоёр туслах зам нь шат дараалсан хэлбэртэй байна.

Бүх уулзварт, туслах замын налуу нь 3%-с хэтрэхгүй байна, ойртох зай хэмжээ нь 30 метр, 50 метр байвал бүр сайн, ингэснээр зогсох, хөдөлгөөнөө эхлэх, гол замын хөдөлгөөнийг ажиглах тэгш талбай гаргаж, уулзвараас хангалттай ус зайлуулах боломжийг хангана.

Лавлагаа А Хэсэг 2.5-с замын уулзварын талаархи нарийвчилсан зөвлөмж, зааварчилгааг авна уу.

4.1.6 Замын тэмдэг

| Зам барих болон замд засвар үйлчилгээ хийх журам | | |
|---|---|------------------|
| Хүчин төгөлдөр болох огноо: 2012.04.16 | Баримт бичгийн дугаар: ОТ-10-СЗ-PRC-0001-М | Хувилбар: 1.1 |

Ерөнхийдөө замын хөдөлгөөний дүрэм нь хамгийн гол байх бөгөөд бүх тохиолдолд таарах ёстой. Таарахгүй тохиолдол гарвал, замын хөдөлгөөнд оролцогч бүр замын тэмдгийн заалтыг заавал биелүүлэх бөгөөд замын тэмдэгт байнга засвар үйлчилгээ хийнэ.

Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм үйлчилнэ.

Лавлагаа А Хэсэг 2.6-с замын тэмдэгийн талаархи нарийвчилсан зөвлөмж, зааварчилгааг авна уу.

ЭМААБО Стандарт Зарлал, Тэмдэгийн Журамаас нарийвчилсан заалтыг харна уу.

4.1.7 Тэмдэгт багана

Тэмдэгт баганыг замын зах ирмэгийг зааж тэмдэглэхэд, ялангуяа шөнийн цагт явуулах ажиллагааг сайжруулах зорилгоор ашиглана. Эдгээр нь хөнгөн бат бөх материалаар хийгдсэн (мод эсвэл PVC хуванцар хоолой) байх ёстой бөгөөд цагаан дээр улаан өнгөтэй чиглүүлэх хэрэгслүүдийг будаж, ирж байгаа замын хөдөлгөөн рүү харуулахаар тогтоосон байна. Цагаан чиглүүлэх хэрэгслүүдийг тэмдэгт баганы эсрэг талд тогтооно.

Лавлагаа А Хэсэг 2.7-с тэмдэгт багануудын талаархи нарийвчилсан зөвлөмж, зааварчилгааг авна уу.

4.2 Барилга

Өндөр үзүүлэлттэй зам бий болгоход үр нөлөөтэй барилгын арга барил нь чухал. Журмын энэ хэсэгт аливаа барилгын техникийн үзүүлэлтэд хөндөх ёстой гол асуудлыг тусгасан.

4.2.1 Зөөлөн дэвсгэр үетэй нөхцөл байдал

Зөөлөн дэвсгэр үетэй нөхцөл байдалд, дараах үндсэн зарчмыг зөвлөмж болгож байна:

- Замыг барихдаа зүсэлтийн аргыг хэрэглэж, уламжлалт зүсэлт, булалтын балансын арга барилаас татгалзах.
- Ухсан хөрс, стандартад нийцэхгүй материалыг хаях.
- Дэвсгэр үед хийх ажлыг багасгах. Дэвсгэр үеийг хангалтгүй шахсан тохиолдолд, суурийн доод үеийг зузаатгана.

Лавлагаа А Хэсэг 3.1-с зөөлөн дэвсгэр үетэй нөхцөл байдлын талаархи нарийвчилсан зөвлөмж, зааварчилгааг авна уу.

4.2.2 Ус зайлуулах

Хөрс хуулж зайлуулсны дараа замын дагуу түр зуурын ус зайлуулах шуудуу барих ёстой бөгөөд энэ нь гадаргууны усыг цуглуулж, замын ажлаас холдуулах болно. Замын барилгын ажлын үе шат болгонд болон замын ашиглалтын хугацааны турш замаас тогтмол ус зайлуулах шаардлагатай.

Замын гадаргуун дээр усыг орхиж үлдээвэл, замын хөдөлгөөн нь тогтонги усанд байгаа зөөлөн материалыг хөдөлгөж тогтонги усыг улам гүнзгийрүүлэн томсгож нүх үүсгэх боломжийг бүрдүүлнэ.

Лавлагаа А Хэсэг 3.2-с ус зайлуулах талаархи нарийвчилсан зөвлөмж, зааварчилгааг авна уу.

4.2.3 Бэлтгэл

Лавлагаа А Хэсэг 3.3-с бэлтгэлийн талаархи нарийвчилсан зөвлөмж, зааварчилгааг авна уу.

| Зам барих болон замд засвар үйлчилгээ хийх журам | | |
|---|---|------------------|
| Хүчин төгөлдөр болох огноо: 2012.04.16 | Баримт бичгийн дугаар: ОТ-10-СЗ-PRC-0001-М | Хувилбар: 1.1 |

4.2.4 Зүсэлт, булалт

Хөрсний зүсэлт шаардагдах үед, операторууд маш болгоомжтой хандаж замын налуу эсвэл дэвсгэр үеийн гадаргууны эцсийн хэлбэрийг эвдэхгүй байхыг хичээнэ. Зүсэлтийг газрын шорооны ажлын захаас, хөндөгдөөгүй ургамалтай талбайн ойр эхлүүлж, зүсэлтийг доошоо хүрэх түвшин рүү явуулснаар замын налуу болон дэвсгэр үеийн эцсийн хэлбэрийг хамгийн үр ашигтайгаар хянаж гүйцээнэ.

Булах материалыг ихэнхдээ зүсэлтээс замын газар шорооны ажлын үед авдаг. Материалыг зузаан (0.5-1.5 метр) үе давхрагатайгаар булалтын доод хэсэгт байрлуулж, зүгээр овоолж болохгүй. Бүх үе давхрагуудыг сайн нягтаршуулснаар хөрсний суултаас сэргийлнэ.

Лавлагаа А Хэсэг 3.4-с зүсэлт, булалтын талаархи нарийвчилсан зөвлөмж, зааварчилгааг авна уу.

4.2.5 Нягтаршуулах

Нягтаршуулалт нь материалыг бат бөх болгодог бөгөөд хучилтын давхрага үеийг нягтаршуулах нь хучилтын тэсвэрт нөлөөлөг гол хүчин зүйлийн нэг юм байна. Замын хучилтанд далангаас илүү чанартай нягтаршуулалт хэрэгтэй байдаг.

Нягтаршуулалтын хэлбэрийг эцсийн үр дүнгийн тодорхойлолтоор эсвэл шаардлагатай эцсийн үр дүнд хүрэх аргын нарийвчилсан зааварчилгаагаар зааж болно. Сүүлийн арга нь илүү тохиромжтой байдаг, учир нь эхний арга нь туршилт их шаарддаг юм.

Лавлагаа А Хэсэг 3.5-с нягтаршуулалтын талаархи нарийвчилсан зөвлөмж, зааварчилгааг авна уу.

4.2.6 Хоолой суурилуулах

Лавлагаа А Хэсэг 3.6-с хоолой суурилуулах талаар нарийвчилсан зөвлөмж, зааварчилгааг авна уу.

4.3 Засвар үйлчилгээ

4.3.1 Замын элэгдлийн шалтгаан

Том оврын ачааны машины зам хичнээн сайн төлөвлөгдөж баригдсан ч, түүний гадаргуу нь ачааны машины ачааллаас болж хазайж болно. Эдгээр хазайлтууд бага багаар хуримтлагдсаар байгаад хучилтын эвдрэлд хүргэдэг. Мөн үрэлт болон бороо, хөлдөлт зэрэг байгалийн хүчин зүйлээс болж хучилтын материалын физик элэгдэл гардаг.

Доор дурдсан шалтгаануудас нэг нь эсвэл хэд хэд нь замын гадаргууны тодорхой хэмжээний элэгдлийг үүсгэдэг:

- Хучилтын хийц загварын алдаанаас гарах эвдрэл.
- Хуурай цаг уураас болж тоос мэтийн жижиг хэсгүүд алдагдаж гадаргууны бүтэц задрахад хүрэх.
- Их борооноос болж жижиг хэсгүүд урсаж угаагдан гадаргууны бүтэц задрахад хүрэх.
- Их борооны ус нь гадаргууны материалд шингэж, шаврын үе үүсгэх.
- Их бороо хучилтыг усаар дүүргэж зөөлөн хэсэг болон дэвсгэр үеийн эвдрэл үүсгэх.
- Усны машин хэт усласнаас болж гадаргууны элэгдэл гарч, тогтонги ус үүсэх.
- Бүтээгдэхүүн эсвэл хэтрүүлсэн ачааны материал асгарах.
- Дугуйн мөр гарах.
- Атираа.
- Нүх.

| Зам барих болон замд засвар үйлчилгээ хийх журам | | |
|---|---|------------------|
| Хүчин төгөлдөр болох огноо: 2012.04.16 | Баримт бичгийн дугаар: ОТ-10-СЗ-PRC-0001-М | Хувилбар: 1.1 |

- Хөлдөж хайлах хөрсний өргөлтөөс гарах эвдрэл, хайлах үед хучилтын нягт багасгахад хүрнэ.
- Гинжит хүнд төхөөрөмжөөс гарах эвдрэл.

Лавлагаа А Хэсэг 4.1-с замын элэгдлийн талаар нарийвчилсан зөвлөмж, зааварчилгааг авна уу.

4.3.2 Замын гадаргууны засвар үйлчилгээ

Лавлагаа А Хэсэг 4.2-с замын гадаргууны засвар үйлчилгээний талаар нарийвчилсан зөвлөмж, зааварчилгааг авна уу.

4.3.3 Шороон далан

Тээврийн хэрэгслийн хурдыг сааруулах зорилгоор өнхрөлтийн эсэргүйцлийн хүчийг нэмэгдүүлж сийрэг материал ашиглах талбай бүрт (хурд сааруулах зурвас, шороон далан) тогтмол сийрэг материалын нягтыг шалгаж байх хэрэгтэй. Эдгээр талбай нягтаршуулсан байвал, огтлох зүсэх хэрэгсэлтэй бульдозер ашиглан гадаргууг эвдлэнэ.

Лавлагаа А Хэсэг 4.3-с шороон далангийн талаар нарийвчилсан зөвлөмж, зааварчилгааг авна уу.

4.3.4 Замын тэмдэг, тэмдэгт багана

Сар бүр цэвэрлэгээ хийнэ. Эвдэрсэн эсвэл чанаргүй тэмдэг/тэмдэгт баганыг шууд засах эсвэл солих шаардлагатай.

Лавлагаа А Хэсэг 4.4-с замын тэмдэг, тэмдэгт баганы талаар нарийвчилсан зөвлөмж, зааварчилгааг авна уу.

4.3.5 Ус зайлуулах сувгийн засвар үйлчилгээ

Ус зайлуулах систем гурван хоорондоо хамааралтай үе шаттайгаар ажилладаг:

- Замын гадаргуугаас усыг V үсгийн хэлбэртэй шуудуу руу зайлуулахын тулд бороон нөхцөлд тохирох хангалттай хөндлөн налуутай байна.
- Усыг V үсгийн хэлбэртэй шуудуугаас тухайн газрын ус зайлуулах сувгийн систем руу зайлуулахын тулд V үсгийн хэлбэртэй шуудуу нь тохиромжтой налуутай байна.
- Усыг тухайн газрын ус зайлуулах сувгийн системаас бүс нутгийн ус зайлуулах систем рүү зайлуулахын тулд тохиромжтой бүс нутгийн ус зайлуулах системтай байна.

Эдгээр гурван үе шатын аль нэг нь зөв ажиллахгүй бол, нийт ус зайлуулах систем нь эвдрэнэ.

Лавлагаа А Хэсэг 4.5-с ус зайлуулах сувгийн засвар үйлчилгээний талаар нарийвчилсан зөвлөмж, зааварчилгааг авна уу.

| Зам барих болон замд засвар үйлчилгээ хийх журам | | |
|---|---|------------------|
| Хүчин төгөлдөр болох огноо: 2012.04.16 | Баримт бичгийн дугаар: ОТ-10-СЗ-PRC-0001-М | Хувилбар: 1.1 |

5 ТОДОРХОЙЛОЛТ

Тээврийн хэрэгсэл: Ажлын зорилгоор ашиглагдах аливаа механикжсан дугуйтай тээвэр, үүнд хөнгөн тээврийн хэрэгсэл болон хөдөлгөөнт төхөөрөмж орсон байна; харин галт тэрэгний зүтгүүр болон төмөр замын аливаа машин үүнд хамаарахгүй.

Ёстой: Шаардлагыг заавал биелүүлнэ.

Байвал зохино: Шаардлагыг зөвлөмж болгож байна

6 ЛАВЛАГАА БОЛОН ХОЛБОГДОХ БИЧИГ БАРИМТ

| | Нэр | Байршил |
|-------------------------------------|--|------------------------------|
| Хуулийн болон бусад шаардлага | Рио Тинто компанийн ЭМААБОЧ-ын 10-р хэсэг. Үйл ажиллагааны хяналт | Проспект хуудас |
| Оюу Толгой ЭМААБО Удирдлагын Систем | Рио Тинтогийн том оврын ачааны маины замын загвар, барилга болон засвар үйлчилгээний зааварчилгаа–2004 2 сар(Рио Тинтогийн Техник Үйлчилгээ) [Лавлагаа А] | ЭМААБО-ы Портал цахим хуудас |
| | 10-р хэсэг – Үйл ажиллагааны Хяналт | |
| | ОТ-10-PRC-0005-М-HSE Стандарт Зарлал, Тэмдгийн Журам | |
| | ОТ-10-СЗ-PRC-0005-М-Замын Хөдөлгөөний Удирдлагын Төлөвлөгөө | |
| | ОТ-10-СЗ-PRC-0004-М-Дугуй, обудны Удирдлагын Төлөвлөгөө | |
| | ОТ-10-СЗ-PRC-0006-М- Лицензи, зөвшөөрөл авах Журам | |
| | ОТ-10-СЗ-PRC-0002-М- Хөнгөн Тээврийн хэрэгслийн Журам | |
| | ОТ-10-СЗ-PRC-0003-М-Хүнд Тээврийн хэрэгслийн Журам | |
| | ОТ-10-СЗ-PRC-0001-М- Зам барих болон замын засвар үйлчилгээний Журам | |

| Зам барих болон замд засвар үйлчилгээ хийх журам | | |
|---|---|------------------|
| Хүчин төгөлдөр болох огноо: 2012.04.16 | Баримт бичгийн дугаар: ОТ-10-СЗ-PRC-0001-М | Хувилбар: 1.1 |

7 БАРИМТ БИЧГИЙН ХЯНАЛТ

| | |
|-------------------------------|--|
| Файлын нэр | ОТ-10-СЗ-PRC-0001-М-ОТ Зам барих болон замд засвар үйлчилгээ хийх журам.docx |
| Тайлбар | Зам барих болон замд засвар үйлчилгээ хийх журам |
| Анх зохиосон хүн (хүмүүс) | Жэксон Тэйлор |
| Зохиосон огноо | 2012.03.01 |
| Баталсан | Эндрю Миллер |
| Баталсан огноо | 2012.04.16 |
| Бүртгэлийн өөрчлөлтийн дугаар | ## |

| Эрсдлийн зэрэг | Үнэлгээ хийсэн огноо | Эрсдлийн үнэлгээ хийсэн | Дахин хянах хуваарь | Дараагийн хяналтын огноо |
|----------------|----------------------|-------------------------|---------------------|--------------------------|
| Дунд | 2012.04.16 | Эндрю Миллер | 2 жил тутам | 2014.04.16 |

| Хувилбар | Өөрчлөлт хийсэн огноо | Зохиосон хүн (хүмүүс) | Баталсан | Өөрчлөлтийн тайлбар |
|----------|-----------------------|-----------------------|--------------|--|
| 1.0 | 2012.04.16 | Жэксон Тэйлор | Эндрю Миллер | Анх зохиосон |
| 1.0 | 2012.04.16 | Жэксон Тэйлор | Эндрю Миллер | Баталсан |
| 1.1 | 2012.12.26 | Н. Тогтуур | Б. Долгор | Бичиг баримтанд хяналт хийгдсэн бөгөөд утга санааг нь өөрчлөөгүй болно |